

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨҮГ	Төрийн Өмчит Үйлдвэрийн Газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт
СЯ	Сангийн яам
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ТӨР ЗАСГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ
ЭРХЛЭХ УТУГ-ЫН ДАРГА
Ж.ТАМИР ТАНАА

2020.02.27 № 06/618
танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төр засгийн үйлчилгээг эрхлэх УТУГ -ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Төр засгийн үйлчилгээг эрхлэх УТУГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Төр засгийн үйлчилгээг эрхлэх УТУГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Ж.Тамир Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, НБББББ-ийг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газар ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 01-нээс 2020 оны 02 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Эвиденсе аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 54 тоот бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Олон улсын жишиг, үндэсний стандартад нийцсэн нийтлэг үйлчилгээ үзүүлэх замаар Төр засгийн байгууллагуудад хуулиар тогтоосон зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэх таатай орчин нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хэрэглэгчдэд үзүүлэх нийтлэг үйлчилгээг олон улсын жишиг, үндэсний стандартын түвшинд зохион байгуулж, үйлчилгээний ашигтай, хямд өртөг зардалтай дэвшилтэт хэлбэрүүдийг сонгож ажиллах;
- Төр, засгийн байгууллагын албан ажлын болон тусгай зориулалтын байрны нөхцөл, барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ, хэвийн ажиллагааг найдвартай хангах;
- Төр засгийн байгууллага, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн нийтлэг үйлчилгээг санхүүжүүлэх санхүү, нягтлан бодох бүртгэлийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх;
- Нийтлэг үйлчилгээний үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, хүний нөөцийн хэрэгцээг төлөвлөх, мэргэшүүлэх, давтан сургах ажлыг зохион байгуулах, мэдээллийн технологи, дэвшилтэд арга, шинэ санааг нэвтрүүлэх.

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ болон Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн хувьд өөрчлөлт орсныг мөрдөн ажиллаж байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй.

Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Емералд” программ хангамж ашигладаг байна.

Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 8 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 4,613,595.3 мянган төгрөгөөс тооцон 46,136.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тооцсон суурь үзүүлэлт болон хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзэн 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1 хувь буюу 44,116.0 мянган төгрөгөөр тооцсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,251,727.4 мянган төгрөгөөр буюу 4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	43,615.8	9,525.9	-34,089.9
Авлага	3,450.0	6,439.7	2,989.7
Урьдчилгаа	1,958.0	-	-1,958.0
Бараа материал	1,041,438.9	1,109,330.9	67,892.0
Үндсэн хөрөнгө	29,959,810.2	28,673,249.0	-1,286,561.2
Нийт хөрөнгө	31,050,272.9	29,798,545.5	-1,251,727.4
Өр төлбөр	43,968.2	5,671.3	-38,296.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	31,006,304.7	29,792,874.2	-1,234,430.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	31,050,272.9	29,798,545.5	-1,251,727.4

Авлага дансны үлдэгдэл өссөн нь Сангийн яамнаас буцаан авах татаас санхүүжилтийн 4,000.0 мянган төгрөгийн авлага байна. Мөн байгууллагаас авах авлагын үлдэгдэл 2,439.7 мянган төгрөг байна.

Бараа материал 67,891.2 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас балансаас балансад шилжүүлэн авсан хангамжийн материал 7,904.6 мянган төгрөг, худалдан авсан бусад бараа материалын өсөлтөөс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэлд аж ахуйн материал 25,094.8 мянган төгрөг, хүнсний материал 38,746.7 мянган төгрөг, бэлэн бүтээгдэхүүн 7,390.3 мянган төгрөг, хангамжийн материал 961,905.8 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 64,840.6 мянган төгрөг, барилгын засварын материал 5,646.6 мянган төгрөг, бичиг хэргийн материал 5,706.1 мянган төгрөг тус тус байна.

Тайлант хугацаанд Төр засгийн үйлчилгээг эрхлэх газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Б/228 тоот тушаалаар 69 нэрийн 15,591.4 мянган төгрөгийн үнэ бүхий ашиглалтын шаардлага хангахгүй, хугацаа дууссан багаж хэрэгсэл, хангамжийн материалуудыг актлан данс бүртгэлээс хассан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,286,561.2 мянган төгрөгөөр буурсан нь барилга байгууламжийн дахин үнэлгээгээр ашиглах жилүүд нь багассантай холбоотой байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А.1/4443 тоот албан тоотоор 84,855.4 мянган төгрөгийн анхны үнэтэй, үлдэх өртөггүй 58 нэр төрлийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлээс хассан.

Өр төлбөр дансны үлдэгдэлд газрын төлбөрийн 5,671.3 мянган төгрөгийн өглөг байна. Энэ нь 2019 оны санхүүжилт хүрэлцээгүй, газрын төлбөр нэмэгдсэнтэй холбоотойгоор үүссэн.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой 3,529,425.1 мянган төгрөгийн төсвийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Нийт зардал 3,529,425.1 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,522,461.0 мянган төгрөг, төвлөрүүлэн шилжүүлсэн 6,964.4 мянган төгрөг байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 8 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд нэмж эрсдэл тодорхойлоогүй бөгөөд нийт 8 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитын явцад илэрсэн 2 алдаа, зөрчилд зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А.1/4443 тоотой олгосон зөвшөөрлийн дагуу тус байгууллагын 58 нэр төрлийн 84,855.4 мянган төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг акталсантай холбоотойгоор акталсан хөрөнгийг худалдах шийдвэр гарсан тул орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэхийг авч үзэх шаардлагатай.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн гүйцэтгэлийн талаар 36, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтын талаар 36, бусад 40 мэдээллийг хугацаанд нь оруулж, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 2 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 70 хувьтай байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ шинэчлэх хүрээнд тодорхой ажлуудыг зохион байгуулж эхэлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримттай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх зөвлөмж өгсөн боловч байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тусгасан бүртгэлийн бодлогыг боловсруулаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг хангалтгүй байснаар УСНББОУС-ыг дутуу мөрдөх, буруу хэрэглэх, нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд алдаа гарах.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т заасан “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтын дагуу, хэрэгжиж буй хууль тогтоомж, байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцсэн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдлөг болгон ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж баталгаажуулан мөрдөж ажиллана.

3.2 И баримттай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн журналын дүнг Татварын И баримтын сайтад шивсэн дүнтэй тулгаж үзэхэд 163 ширхэг баримтаар 702,593.5 мянган төгрөгийн худалдан авалт илүү хийсэн дүнтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1.4-т заасан “Үнэн зөв байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Худалдан авалтын мэдээлэл буруу гарах.

3.2.3. Өгсөн зөвлөмж:

И баримтын сайтад шивсэн баримтыг холбогдох анхан шатны баримт, журналтай тулгаж зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

ЗГХЭГ-ын тэргүүн дэд даргын зөвшөөрлөөр “Үндэсний брендийн бодлогын зөвлөл” 2017 оны 4 дүгээр улирлаас манай 9087699 регистрийн дугаар дээр үйл ажиллагаа явуулж байсантай холбоотойгоор Үндэсний брендийн бодлогын зөвлөлийн зөвлөх үйлчилгээ, зар сурталчилгаа, телевизийн нэвтрүүлгийн төлбөр 702.6 сая төгрөгийн и баримт юм. Энэ тухай ЗГХЭГ-ын санхүүд удаа дараа хэлж, ҮББЗ-ийн регистрийг өөрчлүүлэх албан тоот өгсөн байгаа.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,090,462,674.74	1,125,296,506.55
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	43,615,762.00	9,525,854.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	43,615,762.00	9,525,854.00
3121	Төгрөг	43,615,762.00	9,525,854.00
31211	Төрийн сангийн харилцах	43,615,762.00	9,525,854.00
33	АВЛАГА	3,450,000.00	6,439,728.70
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	2,439,728.70
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3,450,000.00	4,000,000.00
34	УРЬДЧИЛГАА	1,957,993.00	-
3471	Урьдчилгаа тооцоо	1,957,993.00	-
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1,957,993.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	1,041,438,919.74	1,109,330,923.85
35300	Бэлэн бүтээгдэхүүн	27,557,169.99	7,390,266.00
354	Хангамжийн материал	1,013,881,749.75	1,101,940,657.85
35410	Бичиг хэргийн материал	10,337,468.67	5,706,131.14
35420	Аж ахуйн материал	24,821,956.48	25,094,853.85
35430	Сэлбэг хэрэгсэл	54,637,528.20	64,840,562.37
35450	Барилгын засварын материал	6,177,884.05	5,646,622.85
35460	Хүнсний материал	37,327,339.50	38,746,682.90
35470	Бусад хангамжийн материал	880,579,572.85	961,905,804.74
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	29,959,810,221.61	28,673,248,989.01
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	29,959,810,221.61	28,673,248,989.01
391	Газар	2,372,048,144.00	2,372,048,144.00
392	Биет хөрөнгө	27,587,762,077.61	26,301,200,845.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	26,129,109,242.00	26,129,109,242.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	60,846,923.48	1,210,660,090.38
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,096,427,604.44	1,092,644,014.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	439,748,144.17	511,410,841.87
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,768,010,388.30	1,726,797,818.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	1,470,493,136.53	1,473,660,032.32
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	249,850,862.00	249,850,862.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,044,677,617.08	1,051,613,327.92
39215	Хуримтлагдсан элэгдэл	729,225,432.03	753,083,455.75
39301	Програм хангамж	33,426,829.85	29,426,829.85
39302	Хуримтлагдсан элэгдэл	33,426,829.85	29,426,829.85
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	31,050,272,896.35	29,798,545,495.56
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	43,968,234.80	5,671,300.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	43,968,234.80	5,671,300.00
413	Өглөг	39,051,174.00	5,671,300.00
4136	Бусад өглөг	39,051,174.00	5,671,300.00
41361	Байгууллагад төлөх өглөг	39,051,174.00	5,671,300.00
414	Урьдчилж орсон орлого	4,917,060.80	-
41440	Бусад урьдчилж орсон орлого	4,917,060.80	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	31,006,304,661.55	29,792,874,195.56
51	Засгийн газрын хувь оролцоо	31,006,304,661.55	29,792,874,195.56

Төр засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	15,303,767,640.17	15,303,767,640.17
51101	Өмч: - төрийн	15,303,767,640.17	15,303,767,640.17
512	Хуримтлагдсан үр дүн	(2,307,228,518.21)	(3,520,658,984.20)
51210	Өмнөх үеийн үр дүн	(800,385,473.13)	(2,307,228,518.21)
51220	Тайлант үеийн үр дүн	(1,506,843,045.08)	(1,213,430,465.99)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	18,009,765,539.59	18,009,765,539.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	31,050,272,896.35	29,798,545,495.56

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,384,443,809.44	4,415,655,208.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	398,204,226.84	463,242,479.00
120	Нийтлэг татварын бус орлого	398,204,226.84	463,242,479.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	383,464,385.03	421,287,456.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	71,572,914.00	45,958,120.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	311,891,471.03	375,329,336.00
120009	Бусад орлого	14,739,841.81	41,955,023.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,986,239,582.60	3,952,412,729.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,062,114,200.00	3,354,425,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,062,114,200.00	3,354,425,100.00
1330	Төсвийн захирагчдаас	924,125,382.60	597,987,629.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	924,125,382.60	597,987,629.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,886,720,902.28	5,629,085,673.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,135,305,789.68	5,177,841,667.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,931,997,033.31	5,060,531,874.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,927,747,532.25	-
210101	Үндсэн цалин	1,927,747,532.25	2,216,506,336.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	232,802,548.40	280,141,381.49
210201	Тэтгэврийн даатгал	158,030,841.59	194,583,429.50
210202	Тэтгэмжийн даатгал	15,360,283.64	17,661,838.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,200,355.13	22,077,297.80
210204	Ажилгүйдлийн даатгал	3,655,552.01	4,165,346.69
210205	Эрүүл мэндийн даатгал	36,555,516.03	41,653,468.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	561,307,010.45	628,086,482.27
210301	Гэрэл, цахилгаан	282,335,390.69	341,508,335.08
210302	Түлш, халаалт	24,832,441.00	213,292,827.41
210303	Цэвэр, бохир ус	54,139,178.76	3,285,319.78
2104	Хангамж, бараа материалын зардал	268,011,078.30	293,486,963.91
210401	Бичиг хэрэг	10,022,864.69	8,137,741.49
210402	Тээвэр, шатахуун	28,081,930.07	25,694,467.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,258,201.76	6,684,164.79
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,463,000.00	6,557,830.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	193,887,545.91	230,821,313.52
210408	Бараа материал акталсны зардал	25,297,535.87	15,591,447.11
2105	Нормативт зардал	1,928,665.00	831,006.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		831,006.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	176,356,349.23	160,151,643.93
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,064,000.00	14,133,340.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,295,050.00	7,060,800.00
210604	Урсгал засвар	165,997,299.23	138,957,503.93
2107	Томилолт, зочны зардал	2,252,200.00	7,700,008.00
210702	Дотоод албан томилолт	2,252,200.00	7,700,008.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,763,614.00	121,484,645.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	90,978,866.00	103,262,120.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,323,400.00	2,216,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,900,550.00	4,212,425.00
210807	Газрын төлбөр	5,194,298.00	11,784,100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	366,500.00	10,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,655,828,035.68	1,352,143,406.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,809,442.03	22,787,174.04
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,638,018,593.65	1,329,356,232.60
212	ТАТААС	26,416,758.00	28,082,700.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	26,416,758.00	28,082,700.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	26,416,758.00	28,082,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	176,891,998.37	89,227,093.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	103,938,847.79	86,262,724.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	71,566,923.79	62,841,424.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		1,035,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,371,924.00	22,386,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	72,953,150.58	2,964,369.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,953,150.58	2,964,369.43
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	751,415,112.60	451,244,006.00
2200	Дотоод эх үүсвэрээр	751,415,112.60	451,244,006.00
221001	Их засвар	751,415,112.60	451,244,006.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(1,502,277,092.84)</u>	<u>(1,213,430,465.99)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,565,952.24	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	4,565,952.24	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(4,565,952.24)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(1,506,843,045.08)</u>	<u>(1,213,430,465.99)</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,446,391,957.63	4,438,225,621.49
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	515,695,467.03	685,803,881.49
120	Нийтлэг татварын бус орлого	515,695,467.03	685,803,881.49
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	515,695,467.03	685,803,881.49
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	350,569,201.03	504,515,014.49
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	165,126,266.00	181,288,867.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,930,696,490.60	3,752,421,740.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,930,696,490.60	3,752,421,740.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,930,696,490.60	3,752,421,740.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,409,295,703.83	4,472,315,529.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,584,329,175.23	4,079,280,155.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,446,418,582.65	4,039,929,851.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,929,849,392.45	2,277,505,288.80
210101	Үндсэн цалин	1,324,569,592.45	1,559,036,118.80
210102	Нэмэгдэл	423,174,800.00	536,364,170.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	182,105,000.00	182,105,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	228,042,494.00	271,718,335.00
210201	Тэтгэврийн даатгал	228,042,494.00	224,798,710.34
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	12,608,924.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	9,149,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	2,287,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	22,873,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	600,478,275.45	628,195,732.27
210301	Гэрэл, цахилгаан	301,224,961.87	315,461,332.27
210302	Түлш, халаалт	188,856,153.00	193,604,400.00
210303	Цэвэр, бохир ус	110,397,160.58	119,130,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	268,147,760.00	338,647,692.99
210401	Бичиг хэрэг	7,068,200.00	7,068,200.00
210402	Тээвэр, шатахуун	17,523,000.00	26,729,517.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,316,300.00	7,858,264.79
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,734,300.00	3,734,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	231,505,960.00	293,257,411.20
2105	Нормативт зардал	12,650,200.00	12,650,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,650,200.00	12,650,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	293,317,654.55	362,936,228.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,830,000.00	16,830,000.00
210602	Тавилга	0.00	30,850,500.00
210604	Урсгал засвар	276,487,654.55	315,255,728.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	107,413,298.00	109,225,200.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	98,196,500.00	99,196,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,025,000.00	4,025,000.00
210807	Газрын төлбөр	5,191,798.00	6,003,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,519,508.20	39,051,174.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,519,508.20	39,051,174.00
212	ТАТААС	19,176,266.00	0.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	19,176,266.00	0.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	19,176,266.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	118,734,326.58	39,350,304.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,331,176.00	32,385,935.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,959,252.00	9,999,635.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,371,924.00	22,386,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	76,403,150.58	6,964,369.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	76,403,150.58	6,964,369.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	37,096,253.80	358,945,466.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	824,966,528.60	393,035,374.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	824,966,528.60	393,035,374.00
2200	Дотоод эх үүсвэрээр	824,966,528.60	393,035,374.00
221001	Их засвар	824,966,528.60	393,035,374.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-824,966,528.60	-393,035,374.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	37,096,253.80	-34,089,908.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,519,508.20	43,615,762.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	43,615,762.00	9,525,854.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	12,931,719,496.17	8,357,817,548.41	-800,385,473.13	20,489,151,571.45
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,931,719,496.17	8,357,817,548.41	-800,385,473.13	20,489,151,571.45
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	9,651,947,991.18	0.00	9,651,947,991.18
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	2,372,048,144.00	0.00	-800,385,473.13	1,571,662,670.87
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-1,506,843,045.08	-1,506,843,045.08
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	15,303,767,640.17	18,009,765,539.59	-2,307,228,518.21	31,006,304,661.55
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,303,767,640.17	18,009,765,539.59	-2,307,228,518.21	31,006,304,661.55
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			-2,307,228,518.21	-2,307,228,518.21
Тайлант үеийн үр дүн			-1,213,430,465.99	-1,213,430,465.99
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,303,767,640.17	18,009,765,539.59	-3,520,658,984.20	29,792,874,195.56

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант он		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,529,425,100.00	3,528,749,897.79	675,202.21	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,529,425,100.00	3,528,749,897.79	675,202.21	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,497,038,800.00	3,496,363,962.79	674,837.21	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,219,702,100.00	2,219,702,100.00	0.00	100.0
210101	Үндсэн цалин	1,489,503,400.00	1,489,503,400.00	0.00	100.0
210102	Нэмэгдэл цалин	548,093,700.00	548,093,700.00	0.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	182,105,000.00	182,105,000.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	271,267,600.00	271,267,600.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	188,165,600.00	188,165,600.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	20,775,500.00	20,775,500.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,620,400.00	16,620,400.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,155,100.00	4,155,100.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,155,100.00	4,155,100.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	622,274,400.00	622,274,400.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	309,540,000.00	309,540,000.00	0.00	100.0
210302	Түлш, халаалт	193,604,400.00	193,604,400.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	119,130,000.00	119,130,000.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	144,894,700.00	144,220,460.79	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	7,068,200.00	7,068,200.00		100.0
210402	Тээвэр, шатахуун	17,523,000.00	17,309,296.00	213,704.00	98.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,318,800.00	7,858,264.79	460,535.21	94.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,734,300.00	3,734,300.00	0.00	108.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	108,250,400.00	108,250,400.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	12,650,200.00	12,650,200.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,650,200.00	12,650,200.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	118,024,600.00	118,024,002.00	598.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,830,000.00	16,830,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	101,194,600.00	101,194,002.00	598.00	98.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	108,225,200.00	108,225,200.00	0.00	100.0

Төр засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	98,196,500.00	98,196,500.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,025,000.00	4,025,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	6,003,700.00	6,003,700.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,386,300.00	32,385,935.00	365.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,386,300.00	32,385,935.00	365.00	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,000,000.00	9,999,635.00	365.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,386,300.00	22,386,300.00	0.00	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,529,425,100.00	3,522,461,030.79	6,964,069.21	99.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,354,425,100.00	3,347,461,030.79	6,964,069.21	99.8
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175,000,000.00	175,000,000.00	0.00	100.0

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Төр засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит</i>	Аудитын код:
2020.02.06			САГ-2020/70 /СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<i>Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газар</i>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
					Албан тушаал	Овог нэр
А	З	4	5		9	10
1	Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх зөвлөмж өгч байсан боловч асуудал давтагдаж байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй байна	-	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх	Захирал, нягтлан бодогч	Ж.Тамир, Г.Нэрж
2	Байгууллагын касс, харилцахын журналд худалдан авалтын журналын бүртгэлд байхгүй 163 удаагийн худалдан авалт и баримтын сайтад шивэгдсэн байна.	-	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх	Захирал, нягтлан бодогч	Ж.Тамир, Г.Нэрж
	Нийт	-				

